

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/24/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Ж.Мөнгөншагай Утас: 90909190 Цахим хаяг: Mungunshagaij@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.БАТНАЙРАМДАЛ
ТАНАА

2022.02.14 № 04
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,671,855.00	29,277,957.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,671,855.00	29,277,957.00
35400	Хангамжийн материал	23,671,855.00	29,277,957.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	70,000.00
35420	Аж ахуйн материал	21,846,855.00	25,689,957.00
35470	Бусад хангамжийн материал	1,825,000.00	3,518,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,349,953,301.01	1,283,245,035.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,349,953,301.01	1,283,245,035.71
39200	Биет хөрөнгө	1,293,296,817.76	1,228,171,092.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,197,832,667.55	1,217,832,667.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,532,015.56	-104,622,636.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,998,000.00	49,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,998,000.00	-49,998,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	135,491,494.25	159,149,207.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-99,210,503.88	-114,089,692.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,218,906.07	118,057,906.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	-66,424,385.92	-79,085,073.36
39214	Бусад үндсэн хөрөнгө	47,479,500.00	47,479,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,558,844.75	-16,550,786.55
39300	Биет бус хөрөнгө	56,656,483.25	55,073,943.29
39303	Бусад биет бус хөрөнгө	61,034,400.00	61,714,860.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-4,377,916.75	-6,640,916.71
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,373,625,156.01	1,312,522,992.71
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,373,625,156.01	1,312,522,992.71
51	Засгийн газрын хувь оролцоо	1,373,625,156.01	1,312,522,992.71
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	598,499,344.26	598,499,344.26
51200	Хуримтлагдсан үр дүн	11,374,219.77	-49,727,943.53
51210	Өмнөх үеийн үр дүн	30,522,511.43	11,374,219.77
51220	Тайлант үеийн үр дүн	-19,148,291.66	-61,102,163.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	763,751,591.98	763,751,591.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,373,625,156.01	1,312,522,992.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	916,732,870.00	818,286,676.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	132,339,970.00	57,737,642.00
120	Нийтлэг татварын бус орлого	132,339,970.00	57,737,642.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,834,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,834,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	28,337,970.00	57,177,173.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,168,000.00	560,469.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	784,392,900.00	760,549,034.00

Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	763,392,900.00	749,814,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	763,392,900.00	749,814,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,000,000.00	10,734,234.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	3,734,234.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,000,000.00	7,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	935,817,865.81	879,388,839.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	935,817,865.81	879,388,839.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	934,664,983.81	872,850,073.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,545,940.00	603,511,253.00
210101	Үндсэн цалин	457,862,268.00	402,491,623.00
210102	Нэмэгдэл	131,626,072.00	181,458,730.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,057,600.00	19,560,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,160,400.00	79,058,319.00
210201	Тэтгэврийн даатгал	54,298,200.00	56,346,992.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,715,600.00	5,814,108.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,572,400.00	4,650,846.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,143,100.00	1,161,737.83
210205	Эрүүл мэндийн даатгал	11,431,100.00	11,084,632.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,183,500.00	42,085,470.00
210301	Гэрэл, цахилгаан	4,390,523.00	1,528,866.00
210302	Түлш, халаалт	53,611,889.00	39,304,092.00
210303	Цэвэр, бохир ус	1,181,088.00	1,252,512.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,644,974.17	18,915,811.00
210401	Бичиг хэрэг	17,368,800.00	5,816,987.00
210402	Тээвэр, шатахуун	5,913,730.00	3,655,674.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,187,700.00	4,429,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	145,300.00	130,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,414,200.00	4,882,580.00
210408	Бараа материал акталсны зардал	15,615,244.17	0.00
2105	Нормативт зардал	52,505,000.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	495,000.00	0.00
210502	Хоол, хүнс	49,310,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,845,800.00	1,084,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,870,200.00	86,700.00
210604	Урсгал засвар	975,600.00	998,000.00
2107	Томилолт, зочны зардал	427,000.00	341,600.00
210702	Дотоод албан томилолт	427,000.00	341,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,567,648.00	2,227,482.00

Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,472,000.00	1,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,079,000.00	533,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	345,280.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	137,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	31,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	459,000.00	453,770.00
210807	Газрын төлбөр	122,368.00	71,012.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,784,721.64	125,625,438.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,740,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,784,721.64	123,885,438.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,152,882.00	6,538,766.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	820,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	820,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	152,882.00	5,718,766.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	152,882.00	5,718,766.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-19,084,995.81	-61,102,163.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	63,295.85	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	63,295.85	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-19,148,291.66	-61,102,163.30

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	598,499,344.26	763,751,591.98	30,522,511.43	1,392,773,447.67
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	598,499,344.26	763,751,591.98	30,522,511.43	1,392,773,447.67
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-19,148,291.66	-19,148,291.66
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	598,499,344.26	763,751,591.98	11,374,219.77	1,373,625,156.01
7	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	598,499,344.26	763,751,591.98	11,374,219.77	1,373,625,156.01
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	598,499,344.26	763,751,591.98	11,374,219.77	1,373,625,156.01
10	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-61,102,163.30	-61,102,163.30
11	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	598,499,344.26	763,751,591.98	-49,727,943.53	1,312,522,992.71

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	886,226,900.00	760,549,034.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,834,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	101,834,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,834,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,834,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	784,392,900.00	760,549,034.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	763,392,900.00	749,814,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	763,392,900.00	749,814,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,000,000.00	10,734,234.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	3,734,234.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,000,000.00	7,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	878,412,900.00	760,549,034.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	878,412,900.00	760,549,034.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	877,260,018.00	754,010,268.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,545,940.00	603,511,253.00
210101	Үндсэн цалин	457,862,268.00	402,491,623.00
210102	Нэмэгдэл	131,626,072.00	181,458,730.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,057,600.00	19,560,900.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,160,400.00	79,058,319.00
210201	Тэтгэврийн даатгал	54,298,200.00	56,346,992.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,715,600.00	5,814,108.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,572,400.00	4,650,846.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,143,100.00	1,161,737.83
210205	Эрүүл мэндийн даатгал	11,431,100.00	11,084,632.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,178,500.00	43,778,470.00
210301	Гэрэл, цахилгаан	4,390,523.00	1,528,866.00
210302	Түлш, халаалт	54,606,889.00	40,997,092.00
210303	Цэвэр, бохир ус	1,181,088.00	1,252,512.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,029,730.00	20,268,444.00
210401	Бичиг хэрэг	17,368,800.00	5,508,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,913,730.00	3,697,674.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,187,700.00	4,389,600.00

**Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	145,300.00	130,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,414,200.00	6,542,370.00
2105	Нормативт зардал	52,505,000.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	495,000.00	0.00
210502	Хоол, хүнс	49,310,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,845,800.00	3,084,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,870,200.00	2,146,100.00
210604	Урсгал засвар	975,600.00	938,600.00
2107	Томилолт, зочны зардал	427,000.00	341,600.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	427,000.00	341,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,567,648.00	2,227,482.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,472,000.00	1,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,079,000.00	533,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	345,280.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	137,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	31,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	459,000.00	453,770.00
210807	Газрын төлбөр	122,368.00	71,012.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,740,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,740,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,152,882.00	6,538,766.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	820,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	820,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	152,882.00	5,718,766.00
213302	Хаагдсан данс	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	152,882.00	5,718,766.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,814,000.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,814,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,814,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,814,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,814,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,814,000.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	864,483,800.00	744,096,034.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	864,483,800.00	744,096,034.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,663,800.00	743,276,034.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,559,200.00	603,511,253.00
210101	Үндсэн цалин	468,154,400.00	402,491,623.00
210102	Нэмэгдэл	118,089,700.00	181,458,730.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,315,100.00	19,560,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,285,500.00	79,058,319.00
210201	Тэтгэврийн даатгал	56,423,100.00	56,346,992.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,715,600.00	5,814,108.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,572,500.00	4,650,846.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,143,100.00	1,161,737.83
210205	Эрүүл мэндийн даатгал	11,431,200.00	11,084,632.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,136,300.00	43,778,470.00
210301	Гэрэл, цахилгаан	1,759,900.00	1,528,866.00
210302	Түлш, халаалт	45,304,000.00	40,997,092.00
210303	Цэвэр, бохир ус	2,072,400.00	1,252,512.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,704,700.00	12,274,210.00
210401	Бичиг хэрэг	1,594,600.00	1,594,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,937,200.00	2,560,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,604,600.00	1,604,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	130,800.00	130,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,437,500.00	6,383,370.00
2105	Нормативт зардал	56,655,000.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	495,000.00	0.00
210502	Хоол, хүнс	53,460,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,074,700.00	3,084,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,136,100.00	2,146,100.00
210604	Урсгал засвар	938,600.00	938,600.00
2107	Томилолт, зочны зардал	341,600.00	341,600.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	341,600.00	341,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,906,800.00	1,227,482.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,595,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	533,500.00	533,500.00

Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	139,100.00	137,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,700.00	31,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	459,000.00	453,770.00
210807	Газрын төлбөр	148,500.00	71,012.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	820,000.00	820,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	820,000.00	820,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	820,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	864,483,800.00	744,096,034.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	749,814,800.00	744,096,034.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	749,814,800.00	744,096,034.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	114,669,000.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,669,000.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	50.00	50.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	50.00	50.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	43.00	43.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,734,234.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,734,234.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,734,234.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,994,234.00
210401	Бичиг хэрэг	3,913,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,136,834.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,785,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	159,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,740,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,400,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,734,234.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,734,234.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 35 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “нийгмийн халамжийн тэтгэвэр”, 5.1.2 “нийгмийн халамжийн тэтгэмж”, 5.1.3 “нийгмийн халамжийн үйлчилгээ”, 5.1.4- д “нийгмийн хөгжлийн үйлчилгээ” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Хүн амын бүлгийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг олгох ажлыг зохион байгуулах” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан албан тушаалтан нь төлөвлөгөөт хяналт шалгалт хийжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэллээ.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 864.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 8.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 6.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн оны эхний үлдэгдлээс 61.1 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал болон үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	23,671,855.00	29,227,957.00	5,556,102.00	23.5
Үндсэн хөрөнгө	1,349,953,301.01	1,283,245,035.71	(66,708,265.30)	-4.9
Нийт хөрөнгө	1,373,625,156.01	1,312,522,992.71	(61,102,163.30)	-4.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,373,625,156.01	1,312,522,992.71	(61,102,163.30)	-4.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,373,625,156.01	1,312,522,992.71	(61,102,163.30)	-4.4

3.5.1. Бараа материалын үлдэгдэл 23.5 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 23.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 34.8 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 0.6 сая төгрөг нийт 35.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 29.7 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 29.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 4.9 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,349.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 57.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж,

тайлант хугацаанд байгуулсан 123.9 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 1,283.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3. Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 61.1 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 990.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 125.8 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 864.5 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 864.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 749.8 сая төгрөгийн санхүүжилт эх үүсвэрийг бүрдүүлснээс 744.1 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 5.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний урсгал зардлууд 5.7 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн сангаас 7.0 сая төгрөг, Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2021 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн А/118 дугаар захирамжаар “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд 0.9 сая төгрөг, Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/653 дугаар захирамжаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт”-ын ажлын санхүүжилтэнд 2.8 сая төгрөг нийт 10.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд тус байгууллагын дарга Ч.Батнайрамдал нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Б/20 тушаалаар даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын дагуу ХНХЯ-ны дэргэдэх салбар зөвлөлөөс аймгийн ХХҮГ-ын дагуу даргын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулах ажлыг эхлүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 83.3 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 864.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 744.1 сая төгрөгийг зарцуулж, 86.1 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь Ахмадын амралт сувиллаас 2021 онд 114.7 сая төгрөгийг төвлөрүүлэн үйл ажиллагаандаа зарцуулах төлөвлөгөөтэй байсан боловч Ковид-19 цар тахлын улмаас амралтын газрын үйл ажиллагааг зогсоосон тул төлөвлөсөн орлогыг төвлөрүүлэх боломжгүй болжээ.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Байгууллагын дарга нь орон нутгийн сонгуульд нэр дэвшин Сонгуулийн тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.4-д заасны дагуу албан ажлаас чөлөөлөгдсөн тул даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч шинээр томилогдон 13.9 сая төгрөгийн цалин олгосон нь зайлшгүй шаардлагатай албан тушаалын томилгоо хийсэн байна.
- Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

Тайлант онд ХХҮГ-ын төсвийг анх 839.7 сая төгрөгөөр баталсан бол тодотголоор 864.5 сая төгрөгөөр буюу 24.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Учир нь ХХҮГ-ын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд сард дунджаар 4.0 сая төгрөгөөр дутагдаж байсантай холбогдуулан тус зардлуудыг 34.1 сая төгрөгөөр, мөн ковид-19 вирусын халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл, аж ахуйн эд зүйлс худалдан авах зардлыг 3.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу тухайн тодотголоор тогтмол болон бусад зардлаас 12.8 сая төгрөгийг хассан бол жилийн эцэст 5.7 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг нийт 18.5 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон нь нийт төсвийн 10.2 хувийг эзэлж байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй тул судалгааг гаргаж ирүүлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны мэдээлэл байршуулалтыг шалгахад байршуулбал зохих нийт 149 мэдээллийг бүрэн, хугацаанд нь мэдээлсэн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Энэ нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд батлагдсан төсвийн тодотголоор 12.8 сая төгрөгийг, төсвийн хэмнэлтээр 5.7 сая төгрөгийг нийт 18.5 сая төгрөг буюу 10.2 хувийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн гэж үзэн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайлангийн түвшний 2, батламж мэдэгдлийн түвшний 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэн ажиллахад алдаа, зөрчил илрээгүй болно.